

АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН

2022.09.19

№

Баянбулаг баг

Аймгийн Засаг даргын 2022 оны А/221 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Баянцагаан суманд ажиллаа.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ :

Тус суманд худалдан авах ажиллагааны чиглэлээр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний хэрэгжилт үр дүнг 2020,2021 онуудад зарлагдсан төсөл арга хэмжээний материалаас түүвэрчлэн үзэж, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn-ээр хууль, журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

- Шалгалтаар сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд 2020 онд 10 төсөл арга хэмжээ, 2021 онд 12, 2022 онд 7 төсөл арга хэмжээ худалдан авахаар төлөвлснөөс 2020 онд 7, 2021 онд 9, 2022 онд 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn-ээр амжилттай зохион байгуулсан. Тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд тухай бүр бүрэн нийтэлсэн байдлыг шалгахад 2020 онд 14-14, 2021 онд 12-12, 2022 онд 10-10 тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд бүрэн нийтэлсэн боловч цаашид анхаарах шаардлагатай дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төсөл арга хэмжээ тус бүрд үнэлгээний хороо байгуулсан боловч зарим үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн гишүүн томилоогүй зэрэг нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.6 дахь хэсгийг зөрчсөн байна.

- Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулж зарлаагүй нь “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх” журмын 3.2.2-д заасныг зөрчсөн.

- Тендер шалгаруулалтад цахим системээр дамжуулан төрийн мэдээллийн хур системээс дамжуулан авах боломжтой тээврийн хэрэгсэл болон хүний нөөцийн мэдээллийг огт ашигладаггүй.

- Үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д заасны дагуу тендерийг хянан үзэж, үнэлж, үнэлгээний дүгнэлт гарган, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид хүргүүлдэг боловч зөвлөмжид бүх

оролцогчийн мэдээллийг тусгаагүй зөвхөн шалгарсан оролцогчийн мэдээллийг оруулсан.

- Гэрээ байгуулах эрхийг захиалагчаас биш үнэлгээний хорооноос олгосон байгаа нь захиалагч ТБОНӨХБАҮХАТХуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д заасан үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үүрэгтэй гэснийг зөрчсөн.

- 2020 онд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 17,5 сая төгрөгийн төсөвтэй Засаг даргын тамгын газрын шатахуун, 19,7 сая төгрөгийн төсөвтэй Эмнэлгийн шатахуун нийлүүлэгчийг тус тус 3 удаа сонгон шалгаруулахаар тендер зарласан боловч үнийн санал ирээгүй тул шууд худалдан авалт хийсэн.

- Сумын ОНХСангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мал эмнэлгийн барилга төсөл арга хэмжээнд сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д заасныг мөрдөөгүй.

- 2019,2020,2021,2022 онуудад тендерт шалгарсан оролцогчдын гэрээг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэж оролцогчруу илгээсэн эсэхийг шалгахад 2019,2020,2021 онуудад шалгарсан оролцогчдын гэрээг огт бүртгээгүй, 2022 онд 1 гэрээ бүртгэсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

- Шалгалтын явцад илэрсэн зөрчлүүдийг арилгах үүднээс цахим системээс лавлагаа татах, гэрээ бүртгэх, үнэлгээний хорооноос захиалагчид хүргүүлдэг зөвлөмж, захиалагчаас оролцогчдод хүргүүлдэг мэдэгдлийн загварыг гарган өгч, нэг тендер шалгаруулалтын материалыг жишиг болгон архивлаж, цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулахад тулгарч буй асуудлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД :

1. Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХуулийн 53 дугаар зүйлийн 53.5.4-д заасны дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn-ээр зохион байгуулах.

2. Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо ТБОНӨХБАҮХАТХуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэх. Мөн тендер шалгаруулалт зохион байгуулахдаа Сангийн сайдын 2021

оны 102, 103 дугаар тушаалаар батлагдсан журмууд, 124,144,145,146 дугаар тушаалаар батлагдсан тендерийн шинэчилсэн жишиг баримтуудыг ашиглах.

3. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх” журмын 3.2.2-д заасны дагуу үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулсны дараа тендерийн урилга, тендерийн баримт бичиг /санхүүгийн шаардлага, тендерийн баталгааны мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, техник тоног төхөөрөмж, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл/-ийг цахим системд нийтэлж байх.

4. ТБОНӨХБАҮХАТХуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ гэснийг мөрдөж ажиллах.

5. Үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2 тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөхдөө хуулийн заалт зөв хэрэглэх. Мөн зөвлөмжид тухайн тендерт оролцсон шалгарсан, шалгараагүй бүх оролцогчдын мэдээллийг хамтад нь тусгах.

6. Гэрээ байгуулах эрхийг үнэлгээний хорооноос биш ТБОНӨХБАҮХАТХуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагч гаргах үүрэгтэй гэж заасны дагуу захиалагчаас гэрээ байгуулах эрхийг олгож байх. Гэрээ байгуулах эрх олгох, мэдэгдэл хүргүүлэхдээ дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг баримтлах.

7. Үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1, 47.7, 47.8-ыг мөрдөж ажиллах, үнэлгээний хорооны бүх гишүүдээр үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр үнэн зөв бөглүүлж, гарын үсгээр баталгаажуулж байх.

8. Үнэлгээний хороо тендерийн баримт бичиг боловсруулахдаа шалгуур үзүүлэлтийг ойлгомжтой тодорхой тавих. Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, хүний нөөцийн дипломын мэдээлэл, тээврийн хэрэгслийн эзэмшлийн гэрчилгээний мэдээлэл, санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын байгууллагад өртэй эсэх тодорхойлолтуудыг тендерийн баримт бичигт заавал шаардахгүйгээр цахим системээс татаж үнэлгээнд ашиглаж байх. Мөн Шүүхийн

тусгай архивын тодорхойлолт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтуудыг цахим системээр ирүүлэхийг шаардаж байх.

9. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж ТБОНӨХБАҮХАТХуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-д заасны дагуу архивын нэгж болгон хадгалах.

10. ТБОНӨХБАҮХАТХуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;” гэж зааснаар 2019, 2020, 2021,2022 онуудад шалгарсан оролцогчдын гэрээг цахим системд нөхөж бүртгэх. Цаашид шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан даруйд гэрээг цахим системд бүртгэж оролцогчруу илгээж байх.

11. Сумын хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын 19-ний байдлаар худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн А3 сертификаттай албан хаагч 3, хөндлөнгийн төлөөлөл 0 нийт 3 хүн байгаа нь тендер шалгаруулалт зохион байгуулахад хангалтгүй байгаа тул Орон нутгийн өмчийн газраас сумдын Засаг дарга нарт 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/237 дугаартай хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

12. Орон нутгийн өмчийн газраас сумдын Засаг дарга нарт худалдан авах ажиллагаа зохион байгуулахад чиглэл өгөх тухай 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/93, 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/134 албан тоотуудад дурдсан зөвлөмжүүдийг цаашид хэрэгжүүлж ажиллах. Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин давтахгүй дээрх асуудлуудыг анхаарч ажиллах зөвлөмжийг өгч ажиллаа.

ТАЙЛАН БИЧСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Н.ЭНХ-АМГАЛАН